3.2.1. Усны тухай хуулийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх

3.2.2. Усны тухай хуулийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газрын доорхи шугам хоолой бүрийг тоолууржуулах.

3.2.3. Усны тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн саяг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг Сав газрын захиргаанд гаргаж өгөх.

3.2.4. Хаягдал бохир усанд биохимийн шинжилгээг хийлгэж, шинжилгээний дүнг шинжилгээний хариу гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх

3.2.5. Ундны усыг физик-химийн шинж чанарт нь тохирсон зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулж стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан усавр хангах

3.2.6. Ундны усны шинжилгээг жилд 2 удаа хийлгэж шинжилгээний дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх.

3.2.7. Бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх эсвэл шууд зайлуулах үүрэгтэй.

3.2.8. Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Усны тухай хуулийн 33.1.14 дэх заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

3.2.9. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, эсхүл хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласны нөхцөлд тогтоосон, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн бол Усны тухай хуулийн 33.1.13 дахь заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

3.2.10. Баталгаажсан усны тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцох

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглалтын тайланг 12 сарын 21-ний дотор Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх

- 4.4. Гэрээний биелэлтийг дараа жилийн 1 дүгээр сард багтаан дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
4.5. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
4.6. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
4.6.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
4.6.2. аль нэг тал татан буугдсан бол.
4.7. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН.

Ус ашиглуулагчийг төлөөлж
Дархан сумын БОХУБ
/Ц.Ганбат/



Хаяг: Дархан сумын Засаг даргын Тамгын
газрын байр, 1 давхарт 101 тоот
Харилцах утас: 98993803

Ус ашиглагчийг төлөөлж:
Арвижих хүдэр ХХК-ны менежер
..... н.Уранбаатар

Хаяг: Хэнтий аймаг Дархан сум 2-р баг
Баргилт Арвижих хүдэр ХХК
утас: 99104766

Бор-Өндөр хот тохижилт ОНТҮГ-ын
Дарга Батлав Э.Эрдэнэбат

Батлав
“Аривжих хүдэр” ХХК –н
Захирал Д.Уранбаатар

Хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ

№ 02

2025 оны 10 сарын 01 өдөр

Бор-Өндөр сум

Монгол улсын Иргэний хууль, Хот суурины усан хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Ус ашиглалтын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг үндэслэн нэг талаас Бор-Өндөр хот тохижилт ОНТҮГ-ыг төлөөлж нягтлан бодогч ажилтай Барчидгүнсэл овогтой Энхтуяа /цаашид хангагч гэх/ нөгөө талаас Аривжих хүдэр ХХК-ны нярав Н.Мөнх-Эрдэнэ нар/ цаашид хэрэглэгч гэх бохир ус татан зайлуулахтай холбогдон гарах харилцааг зохицуулахаар тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийлэг үндэслэл

1.1 Гэрээг 2025 оны 10 сарын 01 ний өдөр байгуулж жилийн хугацаатай мөрдөх бөгөөд гэрээний хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө хэрэглэгч, гэрээг сунгах тухай хүсэлтээ хангагч байгууллагад тавьж нэг жилийн хугацаагаар сунгаж өмнөх гэрээг дүгнэн, хоёр талын төлөөлөл тэмдэглэл хийж сунгалт хийнэ.

1.2 Хэрэв хэрэглэгч албан ёсоор хүсэлтээ гаргаагүй бол гэрээний хугацаа дахин нэг жилээр сунгагдсан гэж үзэж цаашдын харилцаа гэрээний дагуу зохицуулагдана.

1.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахтай холбогдсон харилцааг иргэний хуулийн дагуу зохицуулна.

Хоёр. Хангагчийн эрх үүрэг

2.1 Хангагч нь энэхүү гэрээний 1.1-д заасан хууль дүрмүүд болон бусад холбогдох хууль эрхийн актуудад заагдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2 Хангагч нь “Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын хууль”-ийн 6-р зүйлд заасан техникийн нөхцөл хангасан хэрэглэгчтэй гэрээ байгуулна.

2.3 Хангагч нь хэрэглэгчийн стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангаж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулна.

2.4 Техник, тоног төхөөрөмжид төлөвлөгөөт засвар хийх болон эвдрэл гэмтлийн улмаас хэрэглэгчийг усаар хангах боломжгүй нөхцөл үүссэн тохиодолд хангагч хэрэглэгчид урьдчилан мэдэгдэнэ.

2.5 Усан хангамж, бохир ус татан зайлуулахтай холбогдон гарах хэрэглэгчийн санал, гомдлыг тухай тухай бүр хүлээн авч барагдуулна.

2.6 Усаар хангах, бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хангагчийн буруугаас хэрэглэгчид хохирсон тохиолдолд хангагч хохирлыг шууд хариуцна.

2.7 Мэргэжлийн байгууллагын эрх бүхий ажилтан ажил үүргийн шаардлагаар хэрэглэгчийн тоног төхөөрөмжинд үзлэг шалгалт хийх зорилгоор ажлын байранд нэвтрэх эрхтэй..

Гурав. Хэрэглэгчийн эрх үүрэг

3.1 Хэрэглэгч нь энэхүү 1.1-д заасан хууль дүрмүүд болон холбогдох хууль журмын актуудад заагдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2 Хэрэглэгч нь стандартын шаардлага хангасан усаар хангуулах, хэрэглээнээс гарсан бохир усаа нийлүүлэх эрхтэй.

3.3 Хэрэглэгч нь ус хэрэглэж, бохир ус татан зайлуулах төлбөрөө сар бүрийн 25-ны дотор төлнө.

3.4 Хангагч гэрээнд заасан шаардлага хангасан усаар хангаж, бохир ус татан зайлуулаагүй тохиолдолд төлбөрийг хасч тооцох эрхтэй.

3.5 Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжиндөө засвар үйлчилгээ хийж хэвийн ажиллагааг хангах.

3.6 Барилга объектоо бусдад шилжүүлэх, худалдах тохилдолд хангагчид мэдэгдэн шинэ эзэмшигчийн төлөөлөлтэй хамт сүүлчийн тооцоог хийх ба шинэ хэрэглэгчтэй гэрээ байгуулах нөхцлийг бүрдүүлж өгөх.

3.7 Хэрэглэгч усны хэрэглээгээ тогтмол хянаж усны зүй бус алдагдал гаргахгүй байх.

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1 Хангагч, хэрэглэгч талууд нь зөөврийн цэвэр ус болон бохир ус татан зайлуулсаны үнэ тарифийг талууд харилцан тохиролцоно.

4.2 Үнэ тариф өөрчлөгдвөл эрх бахий байгууллагуудын тогтоол шийдвэрт заасан хугацаанаас эхлэн мөрдөх шийдвэрийг хэрэглэгчид 30 хоногийн өмнө мэдэгдэнэ.

4.3 Үнэ нэмэгдсэнээс хойш 30 хоногийн дотор хэрэглэгч хангагч дээр ирж тооцоогоо дуусгаж гэрээнд өөрчлөлт оруулах ба энэ хугацаанд өөрчлөлт хийгээгүй шинэ үнэ мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

4.4 Хэрэглэгч нь гэрээнд заасан хугацаанд төлбөр тооцоогоо хийгээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.5 хувийн алданги тооцно.

4.5 Цэвэр бохир ус болон бусад үйлчилгээний төлбөрийг 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд хэрэглээг хязгаарлах ба 10 хоногийн дотор зөрчлийг арилгаагүй бол хууль хяналтын байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

4.6 хэрэглэгч нь доорх хүснэгтэд заагдсан үнэ тарифын дагуу сар бүр үзүүлсэн үйлчилгээний дагуу хангагч талтай тооцоо нийлэн төлбөрийг хугацаанд нь барагдуулна.

№	Үйлчилгээний төрөл	Ангилал	Хэмжих нэгж	Үндэслэл	Нэгж үнэ
---	--------------------	---------	-------------	----------	----------

1	Бохир ус соруулах	Зөөврөөр	төгрөг/ рэйс	Гэрээнд заасны дагуу	150.000 төгрөг

Тав. Харилцан хүлээх хариуцлага

5.1 Гэрээтэй холбогдон гарах аливаа асуудлыг 2 тал хамтран шийдвэрлэх ба харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5.2 Энэ гэрээнд заагдаагүй, бусад асуудлыг гэрээг батлах үед мөрдөгдөж байсан Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу зохцуулна.

5.3 Хэрэглэгч нь үндэслэлгүй шалтгаанаар хангагчтай гэрээ байгуулаагүй нь хэрэглэсэн ус, зайлуулсан бохир усны төлбөрөө төлөхгүй байх үндэслэл болохгүй.

5.4 Гэрээнд гарын үсэг зурж тэмдэг дарж харилцан баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж мөрдөгдөх ба гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

Гэрээ байгуулсан

“Бор-Өндөр Хот Тохижилт” ТБАГУТҮГ-ыг

“Аривжих хүдэр” ХХК -г

Төлөөлж ня-бо:


Төлөөлж нярав:

.....Б.Энхтуяа

.....Н.Мөнх-Эрдэнэ

Утас: 99036601

Утас:99104766





Цагаан
зээрийн эрэгчинг ооно, эмэгчинг ш
аргачин, төлийг янзага, эрэгчин
шүдлэнг цэнхэр ооно, охин
шүдлэнг зусаг шаргачин гэнэ.
Голдуу хул шар зүстэй, богино
сүүлтэй, тангийнхаа захаар шар
хүрээтэй, шаргачин нь эвэргүй,
ооно нь арагшаа тахийж үзүүр нь
дотогш эргэн ойртсон шорон хоёр
эвэртэйгээрээ хар сүүлт зэргээс
ялгаатай.

“АРВИЖИХ ХҮДЭР” ХХК

Төмрийн хүдрийн хуурай
баяжуулах үйлдвэр

ЦАГААН ЗЭЭР



Цагаан зээрийн

идэш тэжээл

Цагаан зээр нь тал хээрийн бүсэд түгээмэл ургадаг хялгана, хазаар өвс, тарна, шарилж, шаваг, ботууль, агь, таана, манлир, хүмүүл, хиаг, дэрс зэргээр хооллоно.

Хоногт 800-900 гр өвс иддэг.

Төллөдөг газар

Цагаан зээрийн төллөх үе ихэвчлэн 6-р сарын 10-аас 7-р сарын 10-ны хооронд төлөлдөг. Төллөлтийн хугацаа ойролцоогоор 4-7 хоног дотор шаргачингуудын 80% нь төллөдөг. Цагаан зээр ил задгай устай, дов толгод гүвээ хотос хонхортой дэрс, сөөг өндөр өтгөн өвс бүхий зслүүд нутагт голдуу бөөн олноороо төллөнө.

Цагаан зээрэнд учирч буй аюул занал

- Ган зуд
- Бэлчээрийн доройтол
- Бэлчээрийн давхцал
- Газрын тос
- Гэрийн нохой

Ороо нийллэг

Цагаан зээрийн ороо хөөцөлдөөн 11-р сарын сүүлчээр илэрдэг. Эвцэлдүүлгийн хамгийн эрчимтэй үе 12-р сарын 10-25 хооронд бөгөөд 1-р сарын дунд гэхэд бүрэн дуусдаг. Ороо хөөцөлдөөн эхэлэхэд ооны хүзүүнд дэх хүхээ нь томорч, хүзүү бараан өнгөтэй болдог. Хүч чадалтай ооно 30-40 бүр цаашлаад 60 хүртэлх шаргачин хурааж хээлтүүлдэг. Оонууд ихэвчлэн нэг нэгээрээ салж, өөрийн эзэмшил нутгийг тогтоон, хилээ тэмдэглэсний дараа өөрийн эзэмшил нутгийн хажуугаар өнгөрч буй сүргээс залуу болон бусад бие гүйцсэн оонуудыг хөөж харин шаргачингуудыг өөрийн зэрүүшдээ таслан хурааж авчирдаг байна.

Цагаан зээрийн гайхалтай чадварууд

- Хурдлах чадвар
- Том сүрэг
- Аюулын дохио өгөх
- Цагаан зээр бол тал хээрийн "МЕНЕЖЕР" юм


Экосистем дэх үүрэг, ач холбогдол

Ургамлын үрийг биедээ наалдуулан алс хол тээвэрлэн тарааж, газрыг хөлөөрөө гишгэн хонхойлон үрийг суулгаж салхинд хийсэхээс хамгаалж, ус тогтох нөхцөлийг бүрдүүлдэг.

Зээрийн сэг зэм, хоргол нь газарт шингэж задран байгалийн бордоо болж өвч ургамал ургахад таатай нөлөө үзүүлдэг.

Цагаан зээрийн хурц туруу нь хөрсөн дээрх өнгөрсөн жилийн хагд өвсийг бутлан шим тэжээлийн эргэлтэд оруулж, нялх ургамлын нарны хангамжийг нэмэгдүүлдэг.







ХЭНТИЙ АЙМАГ ДАРХАН СУМЫН АРВИЖИХ ХҮДЭР
ХХК-НЫ "ТЭР БУМ МОД"

2025.10.15


Хараат багийн Баргилтад гэх газарт байх
хуурай соронзон аргаар төмрийн хүдэр боловсруулах
Арвижих хүдэр ХХК нь "тэр бум мод" хөтөлбөрийн
хүрээнд хавар намрын мод тарих өдрүүдэд өөрийн
баяжуулах үйлдвэрийн хашаандаа 2000 ширхэг
хайлаас, сумын ногоон хэрэм төслийн хашаанд 2000
ширхэг хайлаас тарьсан болно.



[illegible][illegible]

Хятад ажилчидын Хувцас Хангамж					
ОВОГ НЭР	УТАС	АЛБАН ТУШААЛ	Каск	Усны гутал	Борооны цув.
Guan Hengchao	85210370	Засварчин	1	1	1
Zhang Qingyue	85210263	Ковш	1	1	0
Li Qingda	85210329	Ковш	1	1	0
Guan Lihua	85210455	Засварчин	1	1	0
Zhao Shenggang	85210341	Засварчин	1	1	0
Wei Shizeng	85210236	Цахилгаан засварчин	1	1	1
Li Ensheng	80291704	Дарга	1		





ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2025 оны 04 дугаар сарын 22-ны өдөр

№08

Бор-Өндөр сум

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ нь нэг талаас Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлэг /цаашид гүйцэтгэгч гэх/ түүнийг төлөөлөн дарга А.Батбаатар, нөгөө талаас "АРВИЖИХ ХҮДЭР" ХХК /цаашид захиалагч гэх/ түүнийг төлөөлж Захирал Д.Уранбаатар /цаашид талууд гэх/ нь дараах нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь "АРВИЖИХ ХҮДЭР" ХХК-ний ажилчдад дараах ажлуудаар хамтран ажиллана. Үүнд:
-Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журмын дагуу ажилчдад урьдчилсан сэргийлэх багц үзлэг, шинжилгээг хийж гүйцэтгэх, эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт гаргах, мэргэжлийн арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах
- 1.2 Талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон тэдгээртэй холбоотой бусад харилуааг энэхүү гэрээгээр зохицуулна.

ХОЁР. ХИЙГДЭХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

- 2.1 Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилчдын ажиллаж буй хөдөлмөрийн нөхцөлтэй уялдуулан шаардлагатай хийгдэх үзлэг шинжилгээнүүдийг тодорхойлох ба Захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Ажилтан тус бүрт эрүүл мэндийн хуудас болон амбулаторын карт нээж үзлэгийн оношийг бичиж, эмчилгээний заавар зөвлөгөө өгөх
- 2.3 Гүйцэтгэгч нь мэргэжлийн өвчтэй байж болзошгүй хүмүүсийг эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцэж асуудлыг шийдэх
- 2.4 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгийг Захиалагчийн товлосон хугацаанд зохих ёсоор хийж гүйцэтгэх
- 2.5 Захиалагч байгууллага нь эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлтэд бичигдсэн зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлангаа тухай бүрт нь өгөх

2.6 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаат үзлэгийг тогтмол хугацаанд, анх ажилд орох ажилтны үзлэгийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

2.7 Захиалагч үзлэгийн төлбөрийг 1 хүний 80.000 төгрөгөөр тооцон Нэгдсэн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн төрийн сангийн 100182720001 тоот дансанд үзлэг эхлэхээс өмнө хийсэн байх

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Захиалагч нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношлогоо, шинжилгээнд хамруулах журмын дагуу ажилчдаа урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах

3.2 эрүүл мэндийн үзлэг хийх хугацааг гүйцэтгэгч талтай тохирч, цаг хугацаанд нь хийлгүүлэх

3.3 Байгууллага нь урьдчилан сэргийлэх багц үзлэгт хамрагдах ажилчдын мэдээллийг /Овог нэр, регистрийн дугаар, утасны дугаар/ захиалагчийн хэлсэн хугацаанд гаргаж өгөх

3.4 Гэрээнд заасан үзлэг шинжилгээнд бүрэн хамруулахад тавигдах шаардлагыг ажилчдад урьдчилан тайлбарлаж бэлтгэл хангуулсан байна.

3.5 Захиалагч нь гэрээнд заасны дагуу баталжаажсан эрүүл мэндийн хуудсан дээрх үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдаж, Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмчээс гаргасан мэргэжлийн тохироо болон дүгнэлт гаргасан хуудсыг хүлээн авч ажилтныг ажлын байранд ажиллуулна.

3.6 Гүйцэтгэгч талаас эмнэлгийн үзлэг үйлчилгээг хэвийн явуулахтай холбоотойгоор өгсөн зөвлөмж зааврыг дагаж мөрдөнө.

3.7 Эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтээ гүйцэтгэгч тал тавих эрхтэй.

3.8 Захиалагч нь чанарын шаардлага хангаагүй ажил гүйцэтгэлийг хүлээж авахгүй байх эрхтэй ба чанарын дутагдалыг арилгахыг шаардах эрхтэй.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

4.1 Гүйцэтгэгч нь үзлэг шинжилгээнд хамрагдахад тавигдах шаардлага, бэлтгэл ажлын талаар үзлэг эхлэхээс өмнө Захиалагчид урьдчилан мэдэгдэх, зааварчилгаа өгөх үүрэгтэй.

4.2 Гүйцэтгэгч нь ажилтнуудыг энэхүү гэрээнд заасан хугацаанд багтаан үзлэгт оруулж, үзлэгийг чанартай эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээгээр үйлчлэх үүрэгтэй.

4.3 Үзлэгийн багийн эмч нар үзлэгийг мэргэжлийн түвшинд чанартай хийж, хүн тус бүрийн эрүүл мэндийн хуудас болон амбулторын картан дээр үзлэгийн хариуг тодорхой бичиж, эмчилгээний заавар, зөвлөмжийг тайлбарлан бичиж өгнө.

4.4 Хугацаат урьдчилан сэргийлэх үзлэгийн эцэст эмч тус бүр үзлэгийн дүн, зонхилон тохиолдож буй өвчлөлийг хэрхэн бууруулах талаар зөвлөмжийг гаргах ба үзлэгийг багийн ахлагч нэгтэн, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүнг илтгэх хуудсаар дүнгийн хурал хийж захиалагч талд хүлээлгэж өгнө.

4.5 Шинээр ажилд орох ажилтанг гэрээнд заасан үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндийн үзлэгийн дүн, мэргэжлийн тохироог гаргаж, тухайн ажлын байранд ажиллахад тэнцэх эсэхэд дүгнэлт гаргана. Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн ажилтнуудад аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар заавар, зөвлөмж өгөх

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Талууд энэ гэрээний үүргийг биелүүлэх ба харилцан бие биенээ хүндэтгэж хамтран ажиллана.

5.2 Гүйцэтгэгч нь гэрээгээр тохирсон хугацаанд ажлыг гүйцэтгээгүй, доголдолтой гүйцэтгэсэн /эрүүл мэндийн хангалттай тусламж үзүүлж чадаагүй, хийгдэх ёстой шинжилгээг орхигдуулсан, мэргэжлийн зөвлөгөөг хангалттай өгөөгүй, дүгнэлт, шинжилгээ оношилгоо, үзлэгийг бодит байдалд нийцүүлэхгүй, шаардлага хангаагүй гаргасан/ тохиолдолд ажлыг үнэ төлбөргүй дахин гүйцэтгэнэ.

5.3 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад нөгөө талын нууцлалын чанартай мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй, ашиг олох зорилгоор ашиглахгүй байх үүргийг хүлээнэ.

5.4 Энэхүү гэрээний 5.3-т заасан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор нөгөө талд учруулсан аливаа хохирлыг буруутай тал бүрэн барагдуулна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1 Талуудын гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн уг гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2 Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэх ба тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих хууль, тогтоомжийн дагуу маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ

Гэрээний нөхцөлтэй танилцаж түүнтэй холбоотой эрх, үүрэг хариуцлагыг ойлгож, зөвшөөрсөн:

А талын төлөөлөгч: "АРВИЖИХ ХҮДЭР" ХХК-ийн

ХАБЭА.....

(гарын үсэг)

(тамга)

/ Г.Гэрэлтуяа/

Хаяг: Дархан сум 2-р баг

Утас: 85011031

Б талын төлөөлөгч: "Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлсэн дарга

(гарын үсэг)

(тамга)

Хаяг: Бор-Өндөр сум

Утас: 96957373





АРВИЖИХ ХҮДЭР ХХК

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
 Онгельсийн гуламж-8, Life tower-1502 тоот
 Утас: 976-99104766
 E-mail: arvikhkhuder@yahoo.com

2025-08-02 № 25/91

танай _____-ны № _____-т

Г _____ Т

Хүсэлт гаргах тухай

Тус компани нь Хэнтий аймгийн Дархан сумын 2-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд танай байгууллагаас "Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээ", "Цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаа" гэсэн чиглэлээр сургалт авах хүсэлтэй байна.

Хүсэлтийг минь харгалзан үзэж бидний ажилд гүн туслалцаа үзүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Д. УРАНБААТАР



АРВИЖИХ ХҮДЭР ХХК

**“АРВИЖИХ ХҮДЭР” ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар: 25\08

Улаанбаатар хот

Г
Галын аюулгүй байдлын дүрэм батлах тухай

Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Арвижих хүдэр” ХХК-ний Галын аюулгүй байдлын дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үйл ажиллагаа хариуцсан менежер /Б.Баярсайхан/, ХАБЭА-н ажилтан /Г.Гэрэлтуяа/ нарт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАГ



Д.УРАНБААТАР



ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин болон ажилтан, байгууллагын эд хөрөнгийг болзошгүй гал түймрийн аюулаас хамгаалах, галын аюулгүй байдлын үндсэн шаардлагыг тогтооход оршино.
- 1.2. Ажилтан, байгууллага Галын аюулгүй байдлын хууль тогтоомж болон энэхүү дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативийн бусад баримт бичгийг дагаж мөрдөнө.
- 1.3. Байгууллага, албан тушаалтан нь галын аюулгүй байдлын хууль тогтоомж болон энэхүү дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативийн бусад баримт бичгийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

Хоёр. Галын аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага

- 2.1. Байгууллагын удирдлага, галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг бүхий албан тушаалтан нь тухайн байгууллагын барилга байгууламж, нутаг дэвсгэрийн хэмжээнд галын аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээнэ.
- 2.2. Байгууллага өөрийн байгууллагын барилга байгууламж, объектын хэмжээнд галын аюулгүй байдлыг хангах дотоод зааврыг объект тус бүрээр баталж мөрдүүлнэ. Галын аюулгүй байдлыг хангах дотоод зааварт дараах асуудлыг тусгасан байна:
 - 2.2.1. нутаг дэвсгэр, барилга байгууламж, өрөө тасалгаа, аврах зам, гарц;
 - 2.2.2. галын аюултай ажил үйлчилгээ явуулах, тоног төхөөрөмж ашиглах, технологийн шат дамжлагын галын аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ;
 - 2.2.3. тэсрэх, галын аюултай болон галын аюултай бодис, материалын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын дүрэм журам, зөвшөөрөгдөх хэм хэмжээ;
 - 2.2.4. ил гал хэрэглэх, галтай ажил явуулах журам, тээврийн хэрэгслийн зам, гарц, тамхи татах байр;
 - 2.2.5. шатах хог хаягдлыг хураах, хадгалах, зайлуулах шат дамжлага, ажлын тусгай зориулалтын хувцас хадгалах, цэвэрлэх журам;
 - 2.2.6. ажлын дараа өрөө тасалгааг хааж үзлэг хийх журам;
 - 2.2.7. шатдаг бодис, материалыг хадгалах, зайлуулах болон тусгай хувцас хэрэглэлийн эмх цэгцгийг хангах арга хэмжээ;
 - 2.2.8. өрөө тасалгаанд байх бүтэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний зөвшөөрөгдөх тоо хэмжээ;
 - 2.2.9. тостой хувцас хадгалах, шатдаг хог хаягдал, тоосыг цэвэрлэх үе шат;
 - 2.2.10. тэсрэх болон гал түймэр үүсэж болзошгүй орчин дахь хэмжих хэрэгслийн (даралт, дулаан хэмжигч г.м) хязгаарын үзүүлэлт;
 - 2.2.11. объектод нэгэн зэрэг байх зөвшөөрөгдөх хүний тоо;
 - 2.2.12. гал түймэр гарсан үед гал унтраах, аврах ангийг дуудах дараалал, тоног төхөөрөмжийг зогсоох, цахилгаан хангамж, агааржуулалт, салхивчийн тоног



АРВИЖИХ ХҮДЭР ХХК

**“АРВИЖИХ ХҮДЭР” ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар: 25/09

Улаанбаатар хот

Г
Галын аюулгүй байдлын журам батлах тухай

Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Арвижих хүдэр” ХХК-ний Галын аюулгүй байдлын журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үйл ажиллагаа хариуцсан менежер /Б.Баярсайхан/, ХАБЭА-н ажилтан /Г.Гэрэлтуяа/ нарт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Д.УРАНБААТАР



Галын аюулгүй байдлын журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилт нь галын аюулгүй байдлыг хангах талаар нийт ажилтнуудын эрх үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү журам нийт ажилтнуудад болон бүх тасгуудад хамааралтай болно.

Хоёр. Нэр томьёо тодорхойлолт

- "гал түймэр" гэж гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг;
- "гал түймэр унтраах" гэж гал түймрийн үед хүний амь насыг аврах, гал түймрийг унтраахын тулд тодорхой хүн хүч, техник хэрэгслээр тохирсон арга, хэлбэрийг ашиглан гүйцэтгэх үйл ажиллагааг;
- "гал түймэр унтраах удирдагч" гэж гал түймэр унтраах үйл ажиллагааг газар дээр нь удирдан зохион байгуулах гал түймэртэй тэмцэх мэргэжлийн алба хаагчийг;
- "галын аюулгүй байдал" гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг;
- "гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж" гэж барилга байгууламж дахь гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах автомат тоног төхөөрөмж, утаа зайлуулах систем, гал унтраах усан хангамж, хүн нэг бүрийн болон нийтийн тусгай аврах хэрэгслийг;
- "галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг" гэж галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журам, заавар, норм, стандартыг;
- "гал түймрийн аюултай нөхцөл байдал" гэж гал түймэр гарсан тохиолдолд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд шууд аюул учруулах нөхцөл бүрдсэнийг;
- "гал түймэр гарсан тухай акт" гэж гал түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан болохыг нотолсон баримт бичгийг;



**АРВИЖИХ ХҮДЭР ХХК**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Энгельсийн гуламж-8, Life tower-1502 тоот
Утас: 976-99104766
E-mail: arvikhkhuder@yahoo.com

2025-08-02 № 25/91

танай _____-ны № _____-т

Г

Г

Хүсэлт гаргах тухай

Тус компани нь Хэнтий аймгийн Дархан сумын 2-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд танай байгууллагаас "Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээ", "Цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаа" гэсэн чиглэлээр сургалт авах хүсэлтэй байна.

Хүсэлтийг минь харгалзан үзэж бидний ажилд гүн туслалцаа үзүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Д. УРАНБААТАР







3.4.4. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн мэдээлэл

“Арвижих хүдэр” ХХК нь 2017 онд БНСУ-ын “Samyoung plant” ХХК-ийн бутлан ангилах, баяжуулах багц тоног төхөөрөмжүүдийг сонгон баяжуулах үйлдвэрийн талбай дээр угсарч суурилуулсан. Тодотгол төсөлд шинээр тоног төхөөрөмж худалдан авахгүй ба, хуучин тоног төхөөрөмж, техник хэрэгслийг үргэлжлүүлэн ашиглана.

Баяжуулах үйлдвэрийн тоос үүсч буй цэгүүд болох 3 шатны бутлуураас хүдэр гарах хэсэг, хүдэр шигших хэсэг, соронзон сепаратороос бүтээгдэхүүн унах хэсэг мөн бутлуур, шигшүүр, сороонзон сепаратор, туузан дамжуулагч дээр хүдэр унаж тоос үүсэхээс сэргийлж нэмэлтээр налуу бункер, төмөр хаалт, резинэн хаалтнууд хийж тоос үүсэхээс хамгаална.



Зураг 6. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн холболтын фото зураг

говсруулсан: “Эрдэнэс инженеринг” ХХК

Чичиргээт тэжээгүүрийн техникийн үзүүлэлт

Хүснэгт 23. Чичиргээт тэжээгүүрийн техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга
1	Тоног төхөөрөмжийн марк		QH-1042
2	Хүдэр орох амсрын хэмжээ	мм	1050*4200
3	Хүчин чадал,	тн/цаг	120
4	Цахилгаан зарцуулалт	кВт	22
5	Нийт жин	тн	7.5
6	Үйлдвэрлэсэн он	он	2017
7	Ашиглалтын хугацаа	жил	6
8	Хэрэглэгдэх тоо	ш	1



Нэгдүгээр шатны бутлуурын техникийн үзүүлэлт

Хүснэгт 24. Хацарт бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга
1	Тоног төхөөрөмжийн марк		FSK-4430
2	Хүдэр орох амсрын хэмжээ	мм	1100*750
3	Ширхэглэлийн хэмжээ	мм	600
4	Хүчин чадал	тн/цаг	125-200
5	Гарах амсрын хэмжээ	мм	100-200
6	Цахилгаан зарцуулалт	кВт	110
7	Нийт жин	тн	20
8	Үйлдвэрлэсэн он	он	2017
9	Ашиглалтын хугацаа	жил	6
10	Хэрэглэгдэх тоо	ш	1



Хоёрдугаар шатны бутлуурын техникийн үзүүлэлт

Хүснэгт 25. Конусан бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга
1	Тоног төхөөрөмжийн марк		MC-200A
2	Хүдэр орох амсрын хэмжээ	мм	150-200
3	Хүчин чадал	тн/цаг	125-200
4	Гарах амсрын хэмжээ	мм	20-50
5	Цахилгаан зарцуулалт	кВт	160
6	Нийт жин	ш	11
7	Үйлдвэрлэсэн он	он	2017
8	Ашиглалтын хугацаа	жил	6
8	Хэрэглэгдэх тоо	ш	1



Гуравдугаар шатны бутлуурын техникийн үзүүлэлт

Хүснэгт 26. Конусан бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк		МС-200В	
2	Хүдэр орох амсрын хэмжээ	мм	50*120	
3	Хүчин чадал	тн/цаг	95-120	
4	Гарах амсрын хэмжээ	мм	10-20	
5	Цахилгаан зарцуулал	кВт	160	
6	Нийт жин	тн	11	
7	Үйлдвэрлэсэн он	он	2017	
8	Ашиглалтын хугацаа	жил	6	
9	Хэрэглэгдэх тоо	ш	1	

Чичиргээт шигшүүрийн техникийн үзүүлэлт

Хүснэгт 27. Чичиргээт шигшүүрийн техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк		ОР3-2460	
2	Шигших талбайн хэмжээ	мм	2400*6000	
3	Торны нүхний хэмжээ	мм	15; 25	
4	Ширхэглэлийн хэмжээ	мм	0-100	
5	Хүчин чадал	тн/цаг	80-150	
6	Цахилгаан зарцуулалт	кВт	45	
7	Шигших давтамж	эрг/мин	850	
8	Далайц	мм	15-20	
9	Нийт жин	тн	15	
10	Үйлдвэрлэсэн он	он	2017	
11	Ашиглалтын хугацаа	жил	6	
12	Хэрэглэгдэх тоо	ш	1	

Анхан шатны соронзон сепараторын техникийн үзүүлэлт

Хүснэгт 28. Хүрдэн соронзон сепараторын техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк		CTL-0818	
2	Хүчин чадал	тн/цаг	65-85	
3	Хүрдний диаметр	мм	800	
4	Хүрдний урт	мм	1800	
5	Соронзон хүчдэл	Гс	3500	
6	Хөдөлгүүрийн чадал	кВт	11	
7	Жин	тн	3.3	
8	Үйлдвэрлэсэн он	он	2017	
9	Ашиглалтын хугацаа	жил	6	
10	Хэрэглэгдэх тоо	ш	2	

Хяналтын шатны соронзон сепараторын техникийн үзүүлэлт

Хүснэгт 29. Хүрдэн соронзон сепараторын техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк		CTL-0818	
2	Хүчин чадал	тн/цаг	65-85	
3	Хүрдний диаметр	мм	800	
4	Хүрдний урт	мм	1800	
5	Соронзон хүчдэл	Гс	3500	
6	Хөдөлгүүрийн чадал	кВт	11	
7	Жин	тн	3.3	
8	Үйлдвэрлэсэн он	он	2017	
9	Ашиглалтын хугацаа	жил	6	
10	Хэрэглэгдэх тоо	ш	1	

Утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт

Утгуурт ачигч нь бутлуурын хүдэр хүлээн авах бункерт хүдрийг тасралтгүй өгөх, баяжмал болон хаягдлыг овоолгод шилжүүлэн хураах, автосавосвалд ачих үүрэгтэй ажиллана.

Хүснэгт 30. Luigong855N маркийн утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга	
1	Утгуурын багтаамж	м³	3	
2	Эргэлтийн радиус	м	6.1	
3	Ачих хамгийн их өндөр	м	3.1	
4	Явах ангийн урт	м	6.3	
5	Явах ангийн өргөн	м	2.7	
6	Их биеийн өндөр	м	3.5	
7	Түлш зарцуулалт	л/цаг	20	
8	Үйлдвэрлэсэн он	он	2019	
9	Ашиглалтын хугацаа	жил	4	
10	Хэрэглэгдэх тоо	ш	2	

Тоос барих төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

Тоос барих төхөөрөмж нь өндөр бүтээмжтэй, 0.005мм-ээс жижиг ширхэглэлтэй тоос барихад тохиромжтой, энгийн хийцтэй, өргөн хэрэглэгддэг уутан тоос цэвэрлэгч төхөөрөмж юм.

Шүүх тоосны хэмжээнээсээ хамаараад тоног төхөөрөмжийн бүтээмж нь 90-98% байна.

Хүснэгт 31. Тоос барих төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк		DMC-144A	
2	Агаарын хэмжээ	м³/ц	8000-10500	
3	Шүүлтүүрийн тоо	ш	144	
4	Шүүлтүүрийн хэмжээ	мм	100*2000	
5	Хэмжээ	м	1.8*2.8*6.1	
6	Эзлэхүүн	м³	40	

Баргилт-Овоогийн төмрийн хүдрийн ордыг түшиглэн байгуулагдсан хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл/тодотгол/

“Арвижих хүдэр”
ХХК

7	Шаардлагатай агаарын хэмжээ	м ³ /с	0.8	
8	Үйлдвэрлэсэн он	он	2022	
9	Ашиглалтын хугацаа	жил	1	
10	Хэрэглэгдэх тоо	ш	3	

Автосамосвалын техникийн үзүүлэлт

Хүснэгт 32. HOWO маркийн автосамосвалын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоон утга
1	Хөдөлгүүрийн загвар	WP12G380E310
2	Хөдөлгүүрийн чадал, кВт (м.х)	280 (381) 2100 эрг/мин
3	Цилиндрийн тоо байрлал	Цуваа 6 (4 тактын)
4	Хамгийн их мушгих момент, Н*м	1600 эрг/мин
5	Ажлын эзлэхүүн, л	7.7
6	Түлшний савны багтаамж, л	420
7	Хүчний дамжуулгын төрөл	7DS180
8	Дугуй	14.00-24-24PR
9	Ачаалал хуваарилалт, кг	
	Урд тэнхлэгт	9000
	Хойд тэнхлэгт	11000
10	Даац, кг	40000
11	Оврын хэмжээ, мм (урт, өргөн, өндөр)	9100x3200x3850
12	Тэвшний геометр багтаамж, м ³	22
13	Дээд хурд, км/цаг	50
14	Түлш зарцуулалт, л/100км	40
15	Эргэх хамгийн бага радиус, м	10

Хүснэгт 33. Баяжуулах үйлдвэрийн нийт тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмжийн марк	Тоо ширхэг	Цахилгаан зарцуулалт, кВт	
				Нэгж	Нийт
1	Чичиргээт тэжээгүүр	QH-1042	1	22	22
2	1-р шатны хацарт бутлуур	FSK-4430	1	110	110
3	2-р шатны конусан бутлуур	Samyoung MC-200A	1	166.6	166.6
4	3-р шатны конусан бутлуур	Samyoung MC-200B	1	166.6	166.6
5	Чичиргээт шигшүүр	Samyoung OP-2460	1	45	45
6	1-р туузан дамжуулагч	900W-9M	1	7.5	7.5
7	2-р туузан дамжуулагч	900W-15M	1	15	15
8	3-р туузан дамжуулагч	900W-6M	1	7.5	7.5
9	4-р туузан дамжуулагч	900W-26M	1	22	22
10	5-р туузан дамжуулагч	750W-7M	1	5.5	5.5
11	6-р туузан дамжуулагч	750W-25M	1	15	15
12	7-р туузан дамжуулагч	600W-15M	1	5.5	5.5
13	8-р туузан дамжуулагч	600W-15M	1	5.5	5.5
14	9-р туузан дамжуулагч	600W-15M	1	5.5	5.5

№	Тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмжийн марк	Тоо ширхэг	Цахилгаан зарцуулалт, кВт	
				Нэгж	Нийт
15	10- туузан дамжуулагч	750W-6M	1	5.5	5.5
16	11-р туузан дамжуулагч	750W-12M	1	11	11
17	12-р туузан дамжуулагч	600W-15M	1	5.5	5.5
18	13-р туузан дамжуулагч	600W-15M	1	7.5	7.5
19	Соронзон сепаратор	CTL-0818	3	11	33
20	Тоос арилгах төхөөрөмж		3	11	33
21	Бусад хэрэглэгч		1	15	15
22	Үйлдвэрийн гэрэлтүүлэг		8	1.5	12
	Нийт		33		721.7

3.5. Хаягдлын овоолго

Баяжуулах үйлдвэрээс -25 мм-ийн ширхэглэлтэй 9 %-ийн төмрийн агуулгатай 175.5 мян.тн хуурай хаягдал гарна. Баяжуулах үйлдвэрээс гарч буй хаягдал дахь төмрийн агуулга бага, Үүнээс баяжуулах үйлдвэрийн гадаад тээврийн замын арчилгаа болон бусад орон нутгийн замын арчилгаанд 10.0-20.0 мян.тн хаягдал хүдэр хэрэглэхээр тооцоход жилд хаягдлын овоолгод байршуулах хаягдлын хэмжээ 130.0-140.0 мян.тн /35.0 мян.м³/ байна.

Хүснэгт 34. Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлын хэмжээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	Нийт
1	Баяжуулах хүдрийн хэмжээ	мян.тн	500.0	500.0	500.0	500.0	500.0	2500.0
2	Үйлдвэрээс гарах хаягдлын хэмжээ	мян.тн	175.5	175.5	175.5	175.5	175.5	877.4
3	Хаягдалд агуулагдах төмрийн агуулга	%	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0
4	Хаягдал дахь төмрийн хэмжээ	мян.тн	15.8	15.8	15.8	15.8	15.8	79.2
5	Зам засварын ажилд хэрэглэх хаягдлын хэмжээ	мян.тн	40	40	40	40	40	200.0
6	Овоолгод байршуулах хаягдлын хэмжээ	мян.тн	135.5	135.5	135.5	135.5	135.5	677.4
		мян.м ³	32.3	32.3	32.3	32.3	32.3	161.3

Хаягдлын овоолгыг өөрийн эзэмшлийн талбайд, баяжуулах үйлдвэрийн урд талд 50-100 м зайд 100х170.0 м хэмжээтэй газар байгуулахаар төлөвлөсөн. Хүдэр баяжуулах үйлдвэрийн хаягдлын овоолго доорх нөхцөл шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Үйлдвэр ажиллах хугацаанд гарах хаягдлыг багтаах хангалттай багтаамжтай байх
- Хүрээлэн буй байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл бага байх
- Үйлдвэрлэлийн үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах
- Бүтээгдэхүүн тээвэрлэх зардал хямд байх
- Хаягдал тээвэрлэхтэй холбоотой хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл хамгийн бага байх



АРВИЖИХ ХҮДЭР ХХК

**“АРВИЖИХ ХҮДЭР” ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар: 25/07

Улаанбаатар хот

Г
Цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны заавар батлах тухай Г

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


Арвижих хүдэр” ХХК-ны “Цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны заавар”-ыг хавсралтаар баталсугай.

. Цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны зааврыг нийт ажилчдад танилцуулан, мөрдүүлж ажиллахыг ХАБЭА-н ажилтан /Г.Гэрэлтуяа/, инженер /Х.Оюунтөгс/ нарт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Д.УРАНБААТАР




ЦАХИЛГААН АШИГЛАЛТЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

1. Энэхүү заавар нь ажиллагаанд байгаа цахилгаан төхөөрөмжийг ашиглах, засварлаж байгаа хүмүүст зориулагдахаас гадна хүчдэлтэй орчинд орж гардаг ажилчдад нэгэн адил хамаарагдана.
2. Аюулгүйн ажиллагааны талаас тоног төхөөрөмжүүдийг 1000в-оос доош хэвийн хүчдэлтэй, 1000в-оос дээш өндөр хүчдэлтэй гэж ангилна.
3. Тоноглолын ажиллагааны горим алдагдаж, аюулгүйн техникийн дүрмийн зөрчил илэрсэн тухайд ажилчин албан хаагч бүр зөрчлийг арилгах талын арга хэмжээг даруй авах ба өөрийн хүчээр засварлаж, гэмтлийг арилгаж чадахгүй тохиолдолд зохих албан тушаалын хүмүүст яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

1000в-оос доош хүчдэлтэй тоног төхөөрөмжтэй харьцахад шаардагдах аюулгүйн техникийн дүрэм шаардлага

1. Цахилгааны засварчин нь өдөр бүр ажилд гарахын өмнө зааварчилгаатай танилцаж гарын үсэг зурж ажилд гарна.
2. 1000в хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид үзлэг үйлчилгээ хийхэд шит, тоноглолын хаалгыг онгойлгож болно. Салгалт хийгээгүй тохиолдолд ямар нэгэн үйлдэл, ажил гүйцэтгэхийг хориглоно.
3. Ажил хийж байгаагаас бусад үед цахилгааны шит, байр цуглуулга, шүүгээний хаалга цоожтой байх ёстой.
4. Хөндийрүүлэх бүрээстэй бахь отвёрка хэрэглэнэ. Хөндийрүүлэх резинэн бээлий богино ханцуйтай хувцастай ажиллах, төмрийн хөрөө, хуурай, төмөр металл хэрэглэж ажиллахыг хориглоно.
5. Шаардлагатай таслалтуудыг хийж, таслах, залгах аппаратууд өөрөө залгагдах буюу тэдгээрийг андуурч залгахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
6. Ажлын байрны дэргэд хүчдэлтэй байгаа, санамсаргүй шүргэж болзошгүй гүйдэл дамжуулах хэсэгт хаалт хашилт хийнэ.
7. Ажил гүйцэтгэхээсээ өмнө хүчдэлтэй байгаа эсэхийг байнга шалгаж үзэж ажилд орох цахилгаан хөдөлгүүр болон түүгээр хөдөлгөөнд ордог механизмын гүйдэл дамжуулах болон эргэлдэх хэсэгт хүрч ажиллах үед цахилгаан хөдөлгүүрийн хүчдэлийг тасалсан байх ёстой.
8. Цахилгаан хөдөлгүүр ажиллаж байхад түүний эргэлдэх хэсгийн хаалтыг авч болохгүй.
9. Багаж хэрэгслүүдээ бүрэн бүтэн болон эвдрэлгүй эсэхийг байнга шалгаж байх шаардлагатай.
10. Хүчдэлийг бүрэн таслаагүй 1000В хүртэл хүчдэлтэй хуваарилах шит, оруулгын байгууламж, ерөнхий шитэнд хийгдэх үзлэг, засварын ажлыг 2-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр наръядаар гүйцэтгэнэ.
11. Урсгал засварын чанартай зарим ажлыг цахилгаан шит, цахилгаан хөдөлгүүрийн ба гэрэлтүүлгийн хэлхээнд удирдах ажилтны зөвшөөрлөөр журналд тэмдэглэн наръядгүйгээр хийж гүйцэтгэж болно.
12. Цахилгаан шит болон бүхий л тоног төхөөрөмжийн тусгаарлагчдыг солих, засварлах зэрэгт хүчдэлийг тасалж зөөврийн газардуулга хийж ажиллана.
13. Хүмүүс ажиллаж байгаа цахилгаан тоног төхөөрөмжинд хүчдэл өгөгдөж болох бүх цэгүүдэд Бүү залга, хүмүүс ажиллаж байна гэдэг плакат өлгөнө.



V. ТЕХНИКИЙН ҮЛЭГ, ҮЙЛЧЛЭГЭЙН ТЭМДЭГЭЭН			
№	Тусгай үйлчилгээний нэр, хаяг, мэдээ	Тусгай үйлчилгээний нэр, хаяг, мэдээ	Тусгай үйлчилгээний нэр, хаяг, мэдээ
2025	Ир малам	Хүндсэн	Тогсоо
5сар 21	Ремонт хийх	Хүндсэн	Тогсоо
6сар	Ремонт хийх	Хүндсэн	Тогсоо
8сар 17	Тос	Хүндсэн	Тогсоо
9сар 3	Ир малам	Хүндсэн	Тогсоо

V. ТЕХНИКИЙН ҮЛЭГ, ҮЙЛЧЛЭГЭЙН ТЭМДЭГЭЭН			
№	Тусгай үйлчилгээний нэр, хаяг, мэдээ	Тусгай үйлчилгээний нэр, хаяг, мэдээ	Тусгай үйлчилгээний нэр, хаяг, мэдээ
2025	Хүндсэн	Хүндсэн	Тогсоо
VI/9	Бүтэцтэй	Хүндсэн	Тогсоо
2025	Хүндсэн	Хүндсэн	Тогсоо
VI/20	Хүндсэн	Хүндсэн	Тогсоо
IX/13	Ремонт	Хүндсэн	Тогсоо
X/8	Хүндсэн	Хүндсэн	Тогсоо

ХАВСРАЛТ 27

ХАВСРАЛТ 28





Батлав
Бор-Өндөр хот тохижилт ОНТҮГ-ын
ДаргаЭ.Эрдэнэбат

Батлав
“Аривжих хүдэр” ХХК –н
ЗахиралД.Уранбаатар

Хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ

№ 02

2025 оны 10 сарын 01 өдөр

Бор-Өндөр сум

Монгол улсын Иргэний хууль, Хот суурины усан хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Ус ашиглалтын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг үндэслэн нэг талаас Бор-Өндөр хот тохижилт ОНТҮГ-ыг төлөөлж нягтлан бодогч ажилтай Барчидгүнсэл овогтой Энхтуяа /цаашид хангагч гэх/ нөгөө талаас Аривжих хүдэр ХХК-ны нярав Н.Мөнх-Эрдэнэ нар/ цаашид хэрэглэгч гэх бохир ус татан зайлуулахтай холбогдон гарах харилцааг зохицуулахаар тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийлэг үндэслэл

1.1 Гэрээг 2025 оны 10 сарын 01 ний өдөр байгуулж жилийн хугацаатай мөрдөх бөгөөд гэрээний хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө хэрэглэгч, гэрээг сунгах тухай хүсэлтээ хангагч байгууллагад тавьж нэг жилийн хугацаагаар сунгаж өмнөх гэрээг дүгнэн, хоёр талын төлөөлөл тэмдэглэл хийж сунгалт хийнэ.

1.2 Хэрэв хэрэглэгч албан ёсоор хүсэлтээ гаргаагүй бол гэрээний хугацаа дахин нэг жилээр сунгагдсан гэж үзэж цаашдын харилцаа гэрээний дагуу зохицуулагдана.

1.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахтай холбогдсон харилцааг иргэний хуулийн дагуу зохицуулна.

Хоёр. Хангагчийн эрх үүрэг

2.1 Хангагч нь энэхүү гэрээний 1.1-д заасан хууль дүрмүүд болон бусад холбогдох хууль эрхийн актуудад заагдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2 Хангагч нь “Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын хууль”-ийн 6-р зүйлд заасан техникийн нөхцөл хангасан хэрэглэгчтэй гэрээ байгуулана.

2.3 Хангагч нь хэрэглэгчийн стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангаж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулна.

2.4 Техник, тоног төхөөрөмжид төлөвлөгөөт засвар хийх болон эвдрэл гэмтлийн улмаас хэрэглэгчийг усаар хангах боломжгүй нөхцөл үүссэн тохиодолд хангагч хэрэглэгчид урьдчилан мэдэгдэнэ.

2.5 Усан хангамж, бохир ус татан зайлуулахтай холбогдон гарах хэрэглэгчийн санал, гомдлыг тухай тухай бүр хүлээн авч барагдуулна.

2.6 Усаар хангах, бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хангагчийн буруугаас хэрэглэгчид хохирсон тохиолдолд хангагч хохирлыг шууд хариуцна.

2.7 Мэргэжлийн байгууллагын эрх бүхий ажилтан ажил үүргийн шаардлагаар хэрэглэгчийн тоног төхөөрөмжинд үзлэг шалгалт хийх зорилгоор ажлын байранд нэвтрэх эрхтэй..

Гурав. Хэрэглэгчийн эрх үүрэг

3.1 Хэрэглэгч нь энэхүү 1.1-д заасан хууль дүрмүүд болон холбогдох хууль журмын актуудад заагдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2 Хэрэглэгч нь стандартын шаардлага хангасан усаар хангуулах, хэрэглээнээс гарсан бохир усаа нийлүүлэх эрхтэй.

3.3 Хэрэглэгч нь ус хэрэглэж, бохир ус татан зайлуулах төлбөрөө сар бүрийн 25-ны дотор төлнө.

3.4 Хангагч гэрээнд заасан шаардлага хангасан усаар хангаж, бохир ус татан зайлуулаагүй тохиолдолд төлбөрийг хасч тооцох эрхтэй.

3.5 Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжиндөө засвар үйлчилгээ хийж хэвийн ажиллагааг хангах.

3.6 Барилга объектоо бусдад шилжүүлэх, худалдах тохилдолд хангагчид мэдэгдэн шинэ эзэмшигчийн төлөөлөлтэй хамт сүүлчийн тооцоог хийх ба шинэ хэрэглэгчтэй гэрээ байгуулах нөхцлийг бүрдүүлж өгөх.

3.7 Хэрэглэгч усны хэрэглээгээ тогтмол хянаж усны зүй бус алдагдал гаргахгүй байх.

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1 Хангагч, хэрэглэгч талууд нь зөөврийн цэвэр ус болон бохир ус татан зайлуулсаны үнэ тарифийг талууд харилцан тохиролцоно.

4.2 Үнэ тариф өөрчлөгдвөл эрх бахий байгууллагуудын тогтоол шийдвэрт заасан хугацаанаас эхлэн мөрдөх шийдвэрийг хэрэглэгчид 30 хоногийн өмнө мэдэгдэнэ.

4.3 Үнэ нэмэгдсэнээс хойш 30 хоногийн дотор хэрэглэгч хангагч дээр ирж тооцоогоо дуусгаж гэрээнд өөрчлөлт оруулах ба энэ хугацаанд өөрчлөлт хийгээгүй шинэ үнэ мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

4.4 Хэрэглэгч нь гэрээнд заасан хугацаанд төлбөр тооцоогоо хийгээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.5 хувийн алданги тооцно.

4.5 Цэвэр бохир ус болон бусад үйлчилгээний төлбөрийг 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд хэрэглээг хязгаарлах ба 10 хоногийн дотор зөрчлийг арилгаагүй бол хууль хяналтын байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

4.6 хэрэглэгч нь доорх хүснэгтэд заагдсан үнэ тарифын дагуу сар бүр үзүүлсэн үйлчилгээний дагуу хангагч талтай тооцоо нийлэн төлбөрийг хугацаанд нь барагдуулна.

№	Үйлчилгээний төрөл	Ангилал	Хэмжих нэгж	Үндэслэл	Нэгж үнэ
---	--------------------	---------	-------------	----------	----------

1	Бохир ус соруулах	Зөөврөөр	төгрөг/ рэйс	Гэрээнд заасны дагуу	150.000 төгрөг

Тав. Харилцан хүлээх хариуцлага

5.1 Гэрээтэй холбогдон гарах аливаа асуудлыг 2 тал хамтран шийдвэрлэх ба харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5.2 Энэ гэрээнд заагдаагүй, бусад асуудлыг гэрээг батлах үед мөрдөгдөж байсан Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу зохцуулна.

